

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ХҮН АМ ЗҮЙ, ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭРДЭНЭБУЛГАНЫ 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагын ялгаатай байдалд нийцүүлэн, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана.							
1.	1.1.Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж, үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэний тоо	81403	60000	Нийгмийн халамжийн сангаас 68.7 мянган хүнд 25.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосноос 1.6 мянган хүнд 2.5 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2.2 мянган хүнд 2.5 тэрбум төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2.1 мянган хүнд 822.1 сая төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 860 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 215.4 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 61.9 мянган хүнд 19.1 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосон байна. Өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 3725 (5.1%)-аар буурч, халамжийн зардал 1.8 (7.9%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Засгийн газрын 247 дугаар тогтоолын дагуу хүнд	2025.01.01 2025.06.01	100%

				хэлбэрийн болон хавсарсан оноштой хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалж байгаа асран хамгаалагч нарт олгох асаргааны тэтгэмжийн хэмжээ 30 хувиар нэмэгдсэнтэй холбогдуулан 163 асран хамгаалагч нарт 1-4 сарын нэмэгдэл болох 85.9 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас нөхөн олгосон. Орлогыг орлуулан тооцох хосолмол аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг аймгийн хэмжээнд 2025 оны 02-р сарын 03-наас 02 дугаар сарын 17-ныг дуустал хугацаанд 15 хоногийн хугацаанд нийт 4428 өрхөөс мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулан ажиллаж ОНТ-өөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Уг мэдээллийн санд үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний босго оноо шинэчлэн батлагдахаар хүлээгдэж байна. Орлогыг орлуулан тооцох хосолмол аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажилд ХХҮГ-ын 23 мэргэжилтэн, 23 багийн нийгмийн ажилтан, 5 жолооч нийт 51 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Мөн судалгааны багийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хоёр сумын Засаг даргын тамгын газар, 29 багийн ажлын алба, цагдаагийн албатай хамтран аюулгүй байдлыг хангаж ажилласан.		
--	--	--	--	--	--	--

2.	1.2.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж,олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй,түргэн шуурхай хүргэнэ.	Мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	350	150	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд ОНТ-өөс 192.5 сая төгрөг батлагдсан. Эхний хагас жилийн байдлаар онцгой тохиолдлын тэтгэмжинд 19 иргэнд 22.8 сая төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан.Үүнд: 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны 6 иргэн, хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй 1 иргэн, гэнэтийн аюул ослын улмаас гэр оронгүй болсон өрх, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон 12 иргэн тус тус хамрагдсан байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 30 иргэн хамрагдсан. ОНОТХҮ-г үзүүлэх иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахад төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулсан. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 58.5 сая, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээ үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 40.5 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд болон байнгын	2025.01.01 2025.06.01	32.6
----	---	---	-----	-----	--	--------------------------	------

					асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 33.5 сая төгрөгийн төсөвт өртгөөр тус тус гүйцэтгүүлэхээр 3 багцад тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, гэрээг байгуулсан. Төлөвлөгөөнд заагдсаны дагуу үйлчилгээг 3,4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.		
3.	1.3. Аймгийн Нийгмийн халамжийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Зөвлөлийн хурлын тоо, хамрагдсан иргэдийн тоо	4/89	2/40	Аймгийн Нийгмийн халамжийн зөвлөлийн хурлыг 2025 оны 03 болон 05 дугаар саруудад тус тус зохион байгуулж нийт 45 иргэнд 32.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг олгох ажлыг зохион байгуулсан. Батсүмбэр дахь Ахмад настны үндэсний төв, Хөвсгөл аймгийн Ахмад настны хөгжлийн төвд тус тус 1, нийт 2 ахмадыг Засаг даргын шилжүүлэн асрамжлуулах шийдвэрийг гаргуулж, хүргүүлж ажилласан.	2025.01.01 2025.06.01	100%
4.	1.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаанууд хэрэгжүүлнэ	Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	60%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийг журамд заасны дагуу улирал бүр 1, нийтдээ 2 удаа хуралдуулсан. Хурлаар 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг баталж, шинээр батлагдсан дүрэм, журмуудыг танилцуулж, гэрээ байгуулж ажилласан ТББ-ууд, төрийн байгууллагуудын 2025 оны эхний хагас жилийн тайланг хэлэлцсэн. Салбар зөвлөл нийтдээ 4 зорилт бүхий 21 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 13 ажлыг хэрэгжүүлж төлөвлөгөөний биелэлт 62%-ийн гүйцэтгэлтэй байна.	2025.01.01 2025.06.01	100%

Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.	2.1.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан, ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд, ажилд зуучлагдсан иргэдийн тоо	1107/1080	500/450	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/30 дугаар тушаалын хавсралтаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны төсвийн хуваарийн дагуу үйл ажиллагааны арга хэмжээг хэрэгжүүлэхээр 5879 иргэнийг хамруулж 2.1 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсан. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд: Хөдөлмөр эрхлэлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан Ejob платформд 369 иргэнийг ажил хайгчаар, 260 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 563 ажил, ажлын байрны захиалга бүртгэсэн. Ажилд зуучлал 263 иргэн, шинэ ажлын байранд 490 иргэн, хөдөлмөр эрхлэлийн чадварын үнэлгээнд 209 иргэн, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг 18 иргэн, ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээллийн үйлчилгээнд бүлгээр 128 иргэн, ганцаарчилсан үйлчилгээнд 81	2025.01.01 2025.06.01	100%
----	---	--	-----------	---------	--	--------------------------	------

				иргэн нийт 1818 иргэн хамрагдаж 3.5 сая төгрөг ХЭДСангаас зарцуулсан. <i>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд:</i> - Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний JOB CENTER төвийг “Монголын хүний нөөцийн менежментийн холбоо” НҮТББ-ын дэргэдэх Хөдөлмөрийн хувийн биржтэй хамтарч захиргааны 4-р байранд 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн нээн ажиллуулж эхэлж байна. Тус үйлчилгээний төвтэй хамтран ажилгүй, ажил идэвхитэй хайж байгаа иргэдэд зориулж Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалтыг Баян-өндөр сумын 8 багийн 7 бүлгийн 128 иргэнд зохион байгуулж 1.8 сая төгрөг зарцуулсан. -Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтын үйл ажиллагааны хүрээнд Чадамжид суурилсан танхимын мэргэжлийн болон ур чадварын цахим сургалтыг 2 үе шаттай зохион байгуулж, хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээнд 135 иргэн хамрагдаж бүртгэл нь баталгаажсан. - “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа” хөтөлбөр болон нэгдсэн удирдамжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг олон нийтэд танилцуулах, мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор бүсчилсэн өдөрлөгүүдийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн		
--	--	--	--	---	--	--

				бус байгууллагуудын удирдлагууд, Аймгийн ахмадын хороо, Цагдаагийн газар, мөн Баян-Өндөр, Жаргалант сумын бүх багийн иргэдийг хамруулан зохион байгуулж, иргэдэд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой бодлого, шийдвэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, мэргэжлийн зөвлөгөө хүргэлээ. Өдөрлөгт багийн ажлын албаны бүрэлдэхүүн, ажилгүй иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн үйлдвэрлэл эрхэлж буй нийт 679 иргэн хамрагдсан. “Таван богд фүүдс” ХХК-тай хамтран хөдөлмөрийн өдөрлөгийг зохион байгуулж, ажил олгогч болон ажил хайгч иргэдийн уулзалт, ажлын байрны талаар мэдээлэл зөвлөгөө өгч 55 иргэнийг ажилд зуучилж, орон нутагт салбараа нээж буй KFC, pizza hat зэрэг түргэн хоолны сүлжээнд ажиллах хүсэлтэй 144 иргэнийг бүртгэж ярилцлага хийсэн. - Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем Ejob платформыг орон нутгийн ETV телевиз болон ETVHD Erdenet, Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, багийн ажлын албаны пэйж хуудасуудаар дамжуулан нийтэд сурталчилснаар ажил олгогч, ажил хайгч иргэдийн бүртгэл нэмэгдсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 537 иргэн хамрагдаж 696.4 сая төгрөг зарцуулсан. Нийтдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2355 иргэнд 699.9 сая төгрөг зарцуулсан.		
--	--	--	--	---	--	--

2.	2.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн арга хэмжээнд хамрагдаж байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	53/67	30/20	-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгуулж арьс шир, эсгий, төмөр, мод модон эдлэл, хүнсий үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, хүнсний хагас боловсруулсан бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүн, малын тэжээлээр үйлдвэрлэл эрхэлж байгаа -Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгт 20 иргэнд 187.0 сая төгрөг, -Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 30 иргэнд 300.0 сая төгрөг, -Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 20 иргэнд 200.0 сая төгрөг, нийт 70 иргэнд 687.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 5.0-10.0 сая төгрөгийг 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэг олгосон. Үүний үр дүнд 70 ажлын байр хадгалагдаж 50 шинэ ажлын байр бий болсон байна. -Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс эрх авсан Эм эс девелопмент консалтинг ХХК-ны сургалтын төвтэй хамтран санхүүгийн дэмжлэгт хамрагдаж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 130, хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэнийг төсөл бичих 1 өдрийн, бизнесээ хөгжүүлэх 2 өдрийн сургалтад, нийт 170 иргэнийг хамруулж сургалтын зардалд 7.6 сая төгрөг зарцуулсан.	2025.01.01 2025.06.01	100%
----	--	---	-------	-------	---	--------------------------	------

					-Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн 13 байгууллагын 32 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж байна. -Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд хүүхэд хамгаалагчаар Цагдаагийн газраас гарсан 2 ахмад настантай гэрээ байгуулан ажиллаж байна.		
3.	2.3.Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл зэрэг нийгмийн түншлэгч талуудын оролцоо бүхий зөвлөлүүдийн үйл ажиллагааг Ажлын албатай хамтран жигд үйл ажиллагаагаар хангаж ажиллах	Зөвлөлүүдийн хурал, жилийн төлөвлөгөө, хийгдсэн үйл ажиллагааны гүйцэтгэл хувь	100	60	Хөдөлмөрийн салбарт түншлэгч талуудыг оролцоог хангасан Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөл тус тус үйл ажиллагаа явуулж байна. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл улиралд 1 удаа хуралдах журмын дагуу 2 удаагийн хурлыг зохион байгуулж 14 арга хэмжээ бүхий хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж 67%-ийн гүйцэтгэлтэй, ХАБЭА-н зөвлөл мөн 2 удаа хуралдаж 12 хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж 58%-ийн гүйцэтгэлтэй ажилласан.	2025.01.01 2025.06.01	100%
Зорилт 3. Бусад төлөвлөгөөт ажлын хүрээнд:							
1.	1.2.ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг	Хэрэгжилтийн хувь	94%	80%	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2025 оны 1-р улиралд батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.Төлөвлөгөөний хэрэгжилт 95.1% байна.	2025.01.01 2025.06.01	100%

	тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх						
2.	1.3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт	90	60	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилд нийт 92 ирсэн бичиг, 166 өргөдөл, Засаг дарга болон удирдлагаас өгсөн 32 шуурхайн үүрэг даалгавар зэргийг тухай бүрт шийдвэрлэх ажлыг хариуцан гүйцэтгэсэн. Засаг даргын 21 захирамж гаргаж, хэрэгжилтийг хангуулж, 146 байгууллагад албан тоот хүргүүлж, үүрэг чиглэл өгч ажилласан. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан.	2025.01.01 2025.06.01	100%
3.	1.4.Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	100%	100%	Иргэдээс ирүүлсэн буцалтгүй тусламжийн 45 өргөдлийг шийдвэрлэж, гэр хүссэн 110 иргэдийн өргөдлийг 2 сумын ЗДТГ-аар нөхцөл байдлын үнэлгээг хийлгүүлж, аймаг, сум, багийн хамтарсан өргөтгөсөн хурлаар судалгааг танилцуулж нийт 66 иргэнд гэр олгох ажлыг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын шийдвэрээр 4 иргэнд гэр олгосон.	2025.01.01 2025.06.01	100%

4.	1.5. Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо	8	Шийдвэр рийн дагуу ажиллас ан байна	Засаг даргын захирамж болон, ЗДТГ-ын даргын тушаал бусад хэлбэрээр байгуулагдсан 3 ажлын хэсэгт орж ажилласан. Даатгуулагч, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллага хооронд гарсан саналын зөрөө, маргааны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах чиглэл бүхий "Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл"-ийн хуралд 4 удаа оролцсон.	2025.01.01 2025.06.01	100%
----	--	------------------------------------	---	---	--	--------------------------	------

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	1.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулах	Иргэдийн үнэмлэхийг чирэгдэлгүй олгосон байна	3000	1800	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам"-ыг үндэслэн аймгийн ЗДТГ-т үнэмлэх баталгаажуулалтын ажлыг зохион байгуулж байна. Үнэмлэх олгохдоо хүүхдэд бол "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс"-ын шийдвэрийг үндэс болгож байна. Баян-Өндөр болон Жаргалант сум иргэдэд зарыг хүргэж, материалуудыг хүлээн авах, хүргүүлсэн маягтын дагуу хүснэгтийг бөглөж бүртгэлийг хийж үнэмлэхийг авчирснаар үнэмлэхийн бичилт хийж, гарын үсэг зурж, баталгаажуулах ажил хийгддэг. 2025 он гарсаар нийтдээ 3318 үнэмлэх мэдээллийн санд бүртгэгдсэн ба шинээр 150 үнэмлэх, сунгуулах 500	2025.01.01 2025.06.01	100%

					нийтдээ 650 үнэмлэх баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, баримтуудыг архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгөхөөр товъёоглон бэлтгэж ажилласан.		
2.	2.1.Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтад ажиллах	Зөвлөл хуралдаж, төлөвлөгөө баталсан байна.	3-аас доошгүй хуралдах	1-ээс доошгүй удаа	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны А/397 захирамжаар зөвлөлийг шинэчлэн байгуулсан. Зөвлөлийн эхний улирлын хурлаар 16 хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн баталж, ОНТ-өөс 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2025 оны 05 дугаар сард 2025-2026 оны хичээлийн жилд 2018, 2019 онд төрсөн 6,7 настай, 2023 онд төрсөн 2 настай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг цэцэрлэг сургуульд хамруулах “Элсэлт” арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр бэлтгэл хангах хурлыг зохион байгуулж, 05 дугаар сарын 30-нд эцэг, эхчүүдэд сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж, СӨББ-д хамрагдаж байсан хүүхдүүдийн шийдвэрийн хуудсыг ЕБС-иудын захирал эрхлэгч нарт гардуулсан.	2025.01.01 2025.06.01	100%
Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт							
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			

	1	2	3	4	5	6	7
1.	1.Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах	Сургалтуудад хамрагдах болон сургалт хийсэн байна.	Цахим сургалт-10, танхим сургалт-2, бусад газарт сургалт хийх-4	Танхим-2 Цахим-5-аас доошгүй	“Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт боловсруулах, төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх арга зүй” сэдэвт Удирдлагын академиас зохион байгуулсан 2 өдрийн сургалтад, “Хэрэгжилтэд суурилсан бодлого-тэгш эрхийн баталгаа” сэдэвт үндэсний зөвлөгөөн, хэлэлцүүлэгт 2 өдөр тус тус танхимаар хамрагдсан. Цахимаар APDC Mongolia Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбооноос 7 хоног бүр явагддаг цахим сургалтууд 12 удаа, Сонсголгүйн боловсрол ТББ-аас зохион байгуулсан цуврал цахим сургалтуудад 3 удаа, нийтдээ 15 удаа цахим сургалтад хамрагдсан.	2025.01.01 2025.06.01	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХҮН АМ ЗҮЙ, ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.ЭРДЭНЭБУЛГАН